



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/270

Мөрөн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйл, 27 дугаар зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/142 дугаар захирамжийн хавсралтын 19 дэх заалтаар иргэн Энхтайвангийн Байгаль (РЖ83030101) нь Мөрөн сумын 10 дугаар багт “Гэр, орон сууц хашаа”-ны зориулалтаар 511м² газар эзэмшиж авсан ба уг эзэмшил газрын талбайн хэмжээг 1149м² болгож ихэсгэж 26 жилийн хугацаагаар эзэмшүүлсэн нь Иргэний хуулийн 135 дугаар зүйлийн 135.1 дэх хэсэгт “...Хөрш залгаа эд хөрөнгийн нэг талын өмчлөгч буюу эзэмшигч нь өөрийн эд хөрөнгөө ашиглахад саад болохооргүй нөгөө талын зайлшгүй шаардлагатай нөлөөллийг хориглон хязгаарлаж болохгүй...” заасныг зөрчсөн учир сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/187 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2.Уг захирамжаар Мөрөн сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/187 дугаар захирамжийг хүчингүй болгосонтой холбогдуулан нэр бүхий иргэний газрыг Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, захирамжийг холбогдох этгээдэд танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, ажиллахыг сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг гардаж авсан өдрөөс хойш хуульд заасан хугацаанд гомдлыг хянан шийдвэрлэх байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024
6712010848